

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/016/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас:70453317 Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас:70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Б.Нямбуу Утас: 70453399 Цахим хаяг: Nyambuub@audit.gov.mn</p>
--	--



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАТ-ЕРӨӨЛТ ТАНАА

2025.02.10 № УБД-2025/016/НА-СТД-ТУЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр, хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн төсвийн гүцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>170,827,269.69</u>	<u>159,474,510.41</u>
33	АВЛАГА	110,260,647.44	80,420,188.16
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	523,486.36	233,948.96
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	109,737,161.08	80,186,239.20
35	БАРАА МАТЕРИАЛ	60,566,622.25	79,054,322.25
351	Түүхий эд материал	3,775,182.25	4,259,882.25
35110	Тусгай зориулалттай материал	3,775,182.25	4,259,882.25
354	Хангамжийн материал	56,791,440.00	74,794,440.00
35410	Бичиг хэргийн материал	7,182,100.00	9,882,100.00
35420	Аж ахуйн материал	9,044,200.00	10,961,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	490,000.00	2,764,300.00
35470	Бусад хангамжийн материал	40,075,140.00	51,186,640.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>747,177,128.34</u>	<u>925,013,606.11</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	747,177,128.34	925,013,606.11
392	Биет хөрөнгө	712,237,128.34	890,073,606.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	548,042,168.00	548,042,168.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51,277,623.48	-58,861,389.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	199,200,000.00	394,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-178,211,110.72	-204,075,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	421,414,207.90	470,369,707.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-304,639,292.08	-323,547,707.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,842,847.55	90,315,347.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,846,068.47	-55,309,518.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,545,000.00	54,545,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,833,000.36	-25,605,000.51
393	Биет бус хөрөнгө	34,940,000.00	34,940,000.00
39301	Программ хангамж	1,430,000.00	1,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,430,000.00	1,430,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34,940,000.00	34,940,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>918,004,398.03</u>	<u>1,084,488,116.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	<u>15,171,744.55</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	15,171,744.55
413	Өглөг	0.00	15,171,744.55
4136	Бусад өглөг	0.00	15,171,744.55
41361	Байгууллагад төлөх өглөг		15,171,744.55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>918,004,398.03</u>	<u>1,069,316,371.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	918,004,398.03	1,069,316,371.97

511	Засгийн газрын оруулсан капитал/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	186,953,634.59	186,953,634.59
51101	-төрийн	186,953,634.59	186,953,634.59
512	Хуримтлагдсан үр дүн	727,037,720.87	878,349,694.81
51220	Тайлант үеийн үр дүн		151,311,973.94
21210	Өмнөх үеийн үр дүн	727,037,720.87	727,037,720.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,013,042.57	4,013,042.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	918,004,398.03	1,084,488,116.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,774,183,989.55	1,971,593,849.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	235,984,813.80	206,971,478.20
120	Нийтлэг татварын бус орлого	235,984,813.80	206,971,478.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	235,984,813.80	206,971,478.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	224,992,852.08	159,626,778.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	10,991,961.72	46,448,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,538,199,175.75	1,764,622,371.08
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,361,044,400.00	1,226,704,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,361,044,400.00	1,226,704,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,324,358.50	537,917,471.08
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,577,600.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,736,200.00	341,879,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,010,558.50	196,037,871.08
1330	Төсвийн захирагчдаас	1,830,417.25	0.00
133003	Хөрөнгийн	1,830,417.25	896,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,783,619,773.74	1,820,281,875.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,783,619,773.74	1,820,281,875.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,526,792,435.91	1,779,364,133.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,004,104,685.01	1,094,731,770.63
210101	Үндсэн цалин	559,394,243.41	643,668,376.95
210102	Нэмэгдэл	310,591,991.60	279,374,893.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,750,000.00	76,480,000.00
210104	Урамшуулал	55,368,450.00	84,408,500.00
210105	Гэрээт ажлын хөлс		10,800,000.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,409,583.19	137,317,982.96
210201	Тэтгэврийн даатгал	77,449,263.14	93,298,049.47
210202	Тэтгэмжийн даатгал	11,381,612.86	10,976,258.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,885,618.11	7,212,447.05
210204	Ажилгүйдлийн даатгал	4,923,618.08	5,166,287.89
210205	Эрүүл мэндийн даатгал	19,769,471.00	20,664,939.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,350,027.21	65,418,668.76
210301	Гэрэл, цахилгаан	4,313,147.86	6,258,403.21
210302	Түлш, халаалт	41,860,538.35	56,155,296.55
210303	Цэвэр, бохир ус	1,376,341.00	3,004,969.00
210304	Байрны түрээс	1,800,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	72,940,554.00	70,056,958.90
210401	Бичиг хэрэг	27,749,600.00	24,038,500.00
210402	Тээвэр, шатахуун	38,545,940.00	39,380,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,368,791.00	2,553,728.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,276,223.00	4,084,100.00
2105	Нормативт зардал	4,560,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,560,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,199,600.00	24,990,000.00
210604	Урсгал засвар	8,199,600.00	24,990,000.00
2107	Томилолт, зочны зардал	69,330,000.00	59,957,250.00
210702	Дотоод албан томилолт	69,330,000.00	59,957,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,394,937.73	7,339,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,091,787.73	6,643,160.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	168,750.00	129,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	0.00
210807	Газрын төлбөр	349,400.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,503,048.77	319,552,342.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,046,265.64	245,388,820.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	7,572,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,456,783.13	66,591,522.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	256,827,337.83	40,917,741.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,714,586.00	14,167,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,199,000.00	300,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	130,515,586.00	13,867,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,112,751.83	26,750,541.38

213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	45,599,266.83	10,057,091.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,513,485.00	16,693,449.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-9,435,784.19	151,311,973.94
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-9,435,784.19	151,311,973.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,781,587,959.50	1,844,062,910.08
1.1	Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	1,844,062,910.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,255,691.00	79,440,539.00
120	Нийтлэг татварын бус орлого	115,255,691.00	79,440,539.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,255,691.00	79,440,539.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,255,691.00	79,440,539.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,666,332,268.50	1,764,622,371.08
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,361,044,400.00	1,226,704,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,361,044,400.00	1,226,704,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	305,287,868.50	537,917,471.08
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,577,600.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,736,200.00	341,879,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	249,974,068.50	196,037,871.08
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,741,602,292.50	1,646,082,910.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,741,602,292.50	1,646,082,910.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,451,386,886.67	1,605,165,168.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	996,873,061.64	1,094,731,770.63
210101	Үндсэн цалин	564,213,983.47	608,363,123.22
210102	Нэмэгдэл	298,540,628.17	314,680,147.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,750,000.00	76,480,000.00
210104	Урамшуулал	55,368,450.00	84,408,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	10,800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,664,073.54	137,317,982.96
210201	Тэтгэврийн даатгал	85,588,559.98	93,298,049.47
210202	Тэтгэмжийн даатгал	10,540,391.47	10,976,258.73

210203	ҮОМШӨ-ний даатгал	5,727,355.21	7,212,447.05
210204	Ажилгүйдлийн даатгал	4,946,553.68	5,166,287.89
210205	Эрүүл мэндийн даатгал	19,861,213.20	20,664,939.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,162,188.86	48,063,300.00
210301	Гэрэл, цахилгаан	6,113,147.86	5,860,000.00
210302	Түлш, халаалт	49,672,700.00	40,570,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,376,341.00	1,632,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,268,000.00	55,521,630.00
210401	Бичиг хэрэг	897,100.00	15,596,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,961,500.00	39,380,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	409,400.00	375,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		169,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	23,164,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,405,000.00
210604	Урсгал засвар		20,759,300.00
2107	Томилолт, зочны зардал	41,974,000.00	44,057,250.00
210702	Дотоод албан томилолт	41,974,000.00	44,057,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,281,600.00	7,272,860.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,851,300.00	6,643,160.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	117,100.00	387,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,400.00	107,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	105,000.00	0.00
210807	Газрын төлбөр	114,800.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	216,163,962.63	195,036,075.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	216,163,962.63	187,464,075.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,572,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	290,215,405.83	40,917,741.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	165,102,654.00	14,167,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,199,000.00	300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,388,068.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	130,515,586.00	13,867,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,112,751.83	26,750,541.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,513,485.00	16,693,449.98
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	45,599,266.83	10,057,091.40

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	39,985,667.00	89,956,463.89
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,985,667.00	197,980,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,985,667.00	197,980,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,985,667.00	197,980,000.00
223001	Бусад хөрөнгө	0.00	195,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-39,985,667.00	-197,980,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	186,953,634.59	4,013,042.57	769,861,573.06		960,828,250.22
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,953,634.59	4,013,042.57	769,861,573.06	0.00	960,828,250.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-42,823,853.28		-42,823,853.28
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,953,634.59	4,013,042.57	727,037,720.87	0.00	918,004,398.03
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	186,953,634.59	4,013,042.57	727,037,720.87	0.00	918,004,398.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,953,634.59	4,013,042.57	727,037,720.87	0.00	918,004,398.03

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			151,311,973.94		151,311,973.94
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,953,634.59	4,013,042.57	878,349,694.81	0.00	1,069,316,371.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,297,210,000.00	1,280,516,550.02	16,693,449.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,297,210,000.00	1,280,516,550.02	16,693,449.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,282,123,100.00	1,275,284,789.02	6,838,310.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,042,406,100.00	1,038,683,507.41	3,722,592.59
210101	Үндсэн цалин	566,281,100.00	608,363,123.22	-42,082,023.22
210102	Нэмэгдэл	377,914,000.00	269,431,884.19	108,482,115.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,272,000.00	76,480,000.00	-24,208,000.00
210104	Урамшуулал	45,939,000.00	84,408,500.00	-38,469,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,325,500.00	131,669,680.40	655,819.60
210201	Тэтгэврийн даатгал	86,775,200.00	89,451,946.99	-2,676,746.99
210202	Тэтгэмжийн даатгал	11,387,600.00	10,523,776.09	863,823.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,693,800.00	6,920,163.72	-1,226,363.72
210204	Ажилгүйдлийн даатгал	5,693,800.00	4,954,801.06	738,998.94
210205	Эрүүл мэндийн даатгал	22,775,100.00	19,818,992.54	2,956,107.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,063,300.00	48,063,300.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	5,860,000.00	5,860,000.00	0.00
210302	Түлш, халаалт	40,570,400.00	40,570,400.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	1,632,900.00	1,632,900.00	0.00

210304	Байрны түрээс	0	0	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,179,500.00	1,141,700.00	1,037,800.00
210401	Бичиг хэрэг	1,246,000.00	597,500.00	648,500.00
210402	Тээвэр, шатахуун	0	0	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	449,000.00	375,000.00	74,000.00
210404	Ном, хэвлэл	0	0	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	484,500.00	169,200.00	315,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	0	0.00
2105	Эд хогшил, урсгал засварын зардал	381,500.00	284,300.00	97,200.00
210503	Урсгал засвар	381,500.00	284,300.00	97,200.00
2107	Томилолт, зочны зардал	340,000.00	340,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	340,000.00	340,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,536,600.00	629,700.00	906,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,053,000.00	6,643,160.00	409,840.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	774,300.00	387,200.00	387,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	107,500.00	107,500.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,900.00	80,000.00	16,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	122,500.00	55,000.00	67,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	273,400.00	0.00	273,400.00
210807	Газрын төлбөр	162,000.00	0.00	162,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,837,600.00	47,829,441.21	8,158.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,837,600.00	47,829,441.21	8,158.79
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	0	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,474,000.00	14,167,200.00	1,306,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,474,000.00	14,167,200.00	1,306,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчийн урамшуулал	15,174,000.00	13,867,200.00	1,306,800.00
213204	Бусад ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	300,000.00	300,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,297,210,000.00		1,297,210,000.00
1310	Улсын төсвөөс санхүүжих	1,226,704,900.00		1,226,704,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,226,704,900.00		1,226,704,900.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС			

	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000,000.00	27,286,074.00	2,713,926.00
131104	Нэмэлт санхүүжилтийн орлого			
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,505,100.00	52,154,465.00	-11,649,365.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
	БАЙГУУЛЛАГЫН ТОО			
	Төсвийн байгууллага	1	1	0
	Төсвөөс гадуур байгууллага			
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41	35	6
	Удирдах ажилтан	1	1	0
	Гүйцэтгэх ажилтан	35	29	6
	Үйлчлэх ажилтан	5	5	0
	Гэрээт ажилтан			

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан/нэмэлт данс

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	385,245,745.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	190,245,745.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	190,245,745.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	56,048,263.22
210102	Нэмэгдэл		45,248,263.22
210105	Гэрээт ажлын хөлс		10,800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	5,648,302.56
210201	Тэтгэврийн даатгал		3,846,102.48
210202	Тэтгэмжийн даатгал		452,482.64
210203	ҮОМШӨ-ний даатгал		292,283.33
210204	Ажилгүйдлийн даатгал		211,486.83
210205	Эрүүл мэндийн даатгал		845,947.28
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	54,379,930.00
210401	Бичиг хэрэг		14,999,300.00
210402	Тээвэр, шатахуун		39,380,630.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	22,880,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,405,000.00
210604	Урсгал засвар		20,475,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	43,717,250.00
210702	Дотоод албан томилолт		43,717,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	7,572,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,572,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	195,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	195,000,000.00
223001	Бусад хөрөнгө		195,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	537,917,471.08
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	537,917,471.08
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		341,879,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		196,037,871.08

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Үйл ажиллагааны чиглэл: Газрын талаар төрөөс баримтлах бодлого, арга хэмжээг тодорхойлох газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хуваарилах, хамгаалах, нөхөн сэргээх болон Монгол улсын хэмжээнд газрын тоо бүртгэл, шилжилт хөдөлгөөн, газарт учирсан хохирол, газар хамгаалах, газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлт, газрын маргаан болон эрх зүйн байдал тэдгээрт гаргасан өөрчлөлтөд дүгнэлт өгөх зэрэг газар зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж ажилладаг.

Байгууллагын зорилго, зорилт

Зорилго:

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын менежмент, геодези, зурагзүйн талаарх төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, хот байгуулалт, барилгажилт, архитектур, төлөвлөлтийн бодлогыг аймаг, сумын батлагдсан төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний эх үүсвэр, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тулгуурлан хэрэгжүүлэх, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтыг хангах замаар иргэдийн ая тухтай амьдрах, орчин нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь үйл ажиллагаандаа Газрын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/З дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн шууд захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна. Тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Увс аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Ст Ти Эс" программ хангамж ашигладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 166,483.7 мянган төгрөгөөр буюу 15.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	110,260.6	80,420.2	-29,840.4
Урьдчилгаа	0.0	0.0	0.0

Бараа материал	60,566.6	79,054.3	18,487.7
Үндсэн хөрөнгө	747,177.1	925,013.6	177,836.5
Нийт хөрөнгө	918,004.4	1,084,488.1	166,483.7
Өр төлбөр	0.00	15,171.7	15,171.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	918,004.4	1,069,316.4	151,312.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	918,004.4	1,084,488.1	166,483.7

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 80,420.2 мянган төгрөг болж 29,840.4 мянган төгрөгөөр буурсан нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний дагуу захиалагчийн хяналтын зардлын авлагад буурсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 79,054.3 мянган төгрөг болж 18,487.7 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалд 36,946.7 мянган төгрөг, аж ахуйн материалд 4,883.2 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэлд 13,412.8 мянган төгрөг, түлш шатах тослох материалд 39,641.1 мянган төгрөг, бусад хангамжийн материалд 20,245.6 мянган төгрөг, тусгай зориулалтын материалд 834.7 мянган төгрөг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас 434.7 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 925,013.6 мянган төгрөг болж 177,836.5 мянган төгрөгөөр өссөн нь 195,000.0 мянган төгрөгөөр авто тээврийн хэрэгсэл, 2,980.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас 472.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 45,975.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж шилжүүлэн авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 15,171.7 мянган төгрөгөөр өссөн нь түлш халаалтын зардлын өр үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,326,968.9 мянга, Үндсэн үйл ажиллагааны орлогоос 120,000.0 мянга, нийт зарлагыг 1,446,968.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийн зардлыг 2025 онд улсын төсвөөс 1,326,968.9 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг 120,000.0 мянга, нийт 1,446,968.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2025 оны 09 дүгээр сард 149,758.9 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,226,704.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 70,505.1 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,226,704.9 мянга, үйл ажиллагааны орлого 79,440.5 мянган төгрөг гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,280,516.6 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 16,693.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулж төвлөрүүлсэн өөрийн үйл ажиллагааны орлогоос 8,935.4 мянган төгрөгийн өөрийн орлогын гүйцэтгэл давж биелсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Улсын төсөв71504-/80101/	1,234,177.9	1,220,812.1	13,365.8	98.9%
	Улсын төсөв71504-/80226/	1,536.6	629.7	906.9	94.2%
	Улсын төсөв71504-/80802/	15,474.0	14,167.2	1,306.8	91.4%
2	Өөрийн орлого71504-/80101,82404/	47,837.6	47,829.4	8.1	99.9%
	Нийт дүн	1,297,210.0	1,280,516.6	16,693.4	98.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий судалгааны дүн

/мянган төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Унаа, хоолны зардал	76,480.0	2025 онд нэг өдрийн хоолны зардал 10.0 мянган төгрөгөөр тооцож жилийн 76,480.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
2	Гадаад томилолт, арга хэмжээ	-	Гадаад томилолтын зардал гараагүй байна.
3	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
4	Программ хангамж	1,430.0	Fiscus, программ ашигладаг.
5	Сургалт, семинар	7,572.0	ГХБХБГ-ын даргын удирдамжийн дагуу Сумдын даамлуудын 2 удаагийн сургалт, семинар
6	Орон тооны цомхотгол	-	Увс аймгийн Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газар нь 2025 онд 35 орон тоо ажиллагааг батлагдсанаас 29 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.
7	Хэвлэл мэдээлэл	3,850.0	Газрын тухай болон барилгын асуудлаар мэдээ, зар сурталчилгаа явуулах.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 341.879.6 мянга, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 196,037.9 мянга нийт 537,917.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнээс: 56,048.3 мянган төгрөгийг цалинд, 5,648.3 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд, 54,379.9 мянган төгрөгийг хангамж материалын зардалд, 22,880.0 мянган төгрөгийг эд хогшил, урсгал засварт 43,717.2 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардалд, 629.7 мянган төгрөгийг нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд, 7,572.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 195,000.0 мянган төгрөгийг бусад хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Газрын Харилцаа, Барилга Хот байгуулалтын газар нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай шууд худалдан авалтыг 48,955.5 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 472.5 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсан байна. Мөн Худалдан авах ажиллагааны газраар дамжуулан тендер зарлуулж 195,000.0 мянган төгрөгийн үнэтэй Ланд-200 маркын авто тээврийн хэрэгсэл худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1,817,007.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,170.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2025 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,820,281.8 мянган төгрөгийн 1 хувь буюу 18,202.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 14,562.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 178, хугацаа хоцроосон мэдээлэл 2, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 3 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын данс бүртгэлд байгаа Land-200 маркын авто машин нь Газрын харилцаа барилга, хот, байгуулалтын газрын жолоочоор ажиллаж байсан Б.Цэндсүрэнгийн хашаанд эвдэрсэн байдалтай байна. Уг асуудлыг аймгийн Цагдаагийн газарт шалгуулахаар шилжүүлэн шийдвэрлэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 354,982.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 103 тоот албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

2024 оны санхүүгийн аудитаар Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа 99-49 УВА улсын дугаартай Ланд 200 авто машин 2023 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр албан томилолтоор Тэс суманд ажиллаж байх хугацаанд Нарийний голд усанд орж компьютер шатсан гэдэг оноштой байсан.Энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн албан бичгээр Улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар Увс аймгийн авто тээврийн газарт хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	354,982.8	1	354,982.8	
Зөвлөмж					100%
Нийт дүн	1	354982,8	1	354,982.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,016.1 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад 25,016.1 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 3,046.5 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 523,5 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 16,888.1 мянган төгрөгөөр илүү, хангамж бараа материалын зардлыг 2,178.7 мянга, байр ашиглалттай холбоотой зардлыг 2,183.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 195.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалт 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалт "Бүх зардал", гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайланд гүйцэтгэлээр тайлагнаагүй	1	25,016.1					1	25,016.1				
Дүн	1	25,016.1					1	25,016.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Нийт дүн												

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



М.БАТСУУРЬ

М.БАТ-АМГАЛАН

Б.НЯМБУУ

2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр